



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 436

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар дахин худалдах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3, 269 дүгээр тогтоолын 2, 3 дугаар заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа газар, албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 75,943,847.00 (далан таван сая есөн зуун дөчин гурван мянга найман зуун дөчин долоон) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүүд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Ажлын хэсэг байгуулж хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт болон хөрөнгийн үнийг байгууллагын дансанд төвлөрүүлсэн баримтын хамт 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0000898

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрийн
436 дугаар тогтоолын хавсралт

**МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬАА ГАЗАР, АЛБАДЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр, дугаар	Үйлдсэн/ Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)	Эзэмшигч байгууллага
1	Бага оврын автобус Ниссан Урбан, улсын дугаар УБЗ 11-59, арлын дугаар 2540011444	2010/2015	36,443,847.00	36,443,847.00	0.00	1,500,000	Буянт-Ухаа боомтын Хилийн мэргэжлийн хяналтын алба
2	Суудлын автомашин Тоёота Карино, улсын дугаар ХОА 49- 28, арлын дугаар АТ 2116079206	2001/2010	8,800,000.00	8,800,000.00	0.00	500,000	Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газар
3	Суудлын автомашин УАЗ-31519, улсын дугаар ХОА 49-29, арлын дугаар ХТТ 315192А0584932	2010/2010	21,200,000.00	21,200,000.00	0.00	500,000	Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газар
4	Суудлын автомашин УАЗ 220695 фургон, улсын дугаар ХОА 26-50, арлын дугаар 374100А0429882	2006/2008	9,500,000.00	9,500,000.00	0.00	500,000	Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газар
	Дүн		75,943,847.00	75,943,847.00	-	3,000,000.00	
			(далан таван сая есөн зуун дөчин гурван мянга найман зуун дөчин долоон)	(далан таван сая есөн зуун дөчин гурван мянга найман зуун дөчин долоон)		(гурван сая)	